



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/92


Улаанбаатар хот

Өнчин эмийн жагсаалтад
нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, "Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны 33 дугаар тэмдэглэлийн 2.1-д заалт, Хүний эмийн зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хэрэглэх Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэлгүй, улсын хэмжээнд харьцангуй бага хэрэглэгддэг, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай, ДЭМБ-ын зөвшөөрсөн хатуу зохицуулалттай орны үйлдвэрийн уналт, таталтын эсрэг хавсралтад дурдсан 10 нэрийн эмийг Эрүүл мэндийн сайдын "Өнчин эмийн жагсаалтыг шинэчлэн батлах тухай" 2015 оны 271 дүгээр тушаалд 2 жилийн хугацаатайгаар нэмж баталсугай.
2. Өнчин эмийн жагсаалтад орсон Диазепам 10мг-2.5мл, 5мг-2.5мл шулуун гэдэсний гель эмийг импортлох, хадгалах, түгээх, тайлагнах үйл ажиллагаанд Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн эргэлтэд хяналт тавих тухай хууль, "Сэтгэцэд нөлөөт бодисуудын тухай" 1971 оны НҮБ-ын Конвенци болон холбогдох журмыг мөрдөн ажиллахыг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар, эм ханган нийлүүлэх байгууллагуудад үүрэг болгосугай.
3. Эпилепси өвчний эмнэлзүйн удирдамжийг 2023 оны 06 дугаар сард багтаан шинэчлэн боловсруулахыг ЭМЯ-ны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газар /М.Оюунчимэг/, холбогдох мэргэжлийн салбар зөвлөл, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт даалгасугай.


САЙД



С.ЧИНЗОРИГ

141223444

03 Эрүүл мэндийн сайдын 2023 оны
... дугаар сарын ... өдрийн ... дугаар
тушаалын хавсралт



Өнчин эмийн жагсаалтад нэмэх уналт, таталтын эсрэг эмийн нэр

№	Олон улсын нэршил	Эмийн тун, хэлбэр	Эмчилгээний хэрэглэх заалт
1	Вигабатрин	500мг, шахмал, капсул	Эмэнд тэсвэртэй эпилепсийн эсрэг бэлдмэл, хүүхдийн эпилепсийн энцефалопати
2	Натрийн дивалпрокс	250мг, шахмал	Тархмал эпилепсийн эмчилгээ
3	Натрийн дивалпрокс	500мг, шахмал	
4	Диазепам	10мг-2.5мл, шулуун гэдэсний гель	Эпилепсийн статус, эпилепсийн сери уналт таталт
5	Диазепам	5мг-2.5мл, шулуун гэдэсний гель	
6	Лакосамид	50мг, шахмал	Хэсэгчилсэн эпилепсийн уналт таталтын эсрэг бэлдмэл
7	Лакосамид	100мг, шахмал	
8	Лакосамид	200мг, шахмал	
9	Окскарбазепин	150мг, шахмал	Эпилепсийн хэсэгчилсэн уналт, Ерөнхий тоник клоник уналт
10	Окскарбазепин	60мг/мл-100мл, сироп	